


БАТЛАВ
УСНЫ ГАЗРЫН ДАРГЫН АЛБАНҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  З.БАТБАЯР

2025 оны 05 сарын 10 өдөр

НЭГ: ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Их Хурлын 2023 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд Авлигатай тэмцэх газраас <http://khutulbur.iaac.mn/iaac> цахим системээр 5 зорилгын хүрээнд 7 зорилтын 9 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг нээж түүний хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тус төлөвлөгөөний Зорилт 2.6-ын 2.6.2-д заасан **“Эрсдэлд суурилсан авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлж хэвшүүлнэ”** заалтыг хангах хүрээнд Авлигатай тэмцэж газраас олон нийтэд ил болгосон “Шударга байдлын үнэлгээ-2024” судалгааны тайлантай танилцахад Усны газарт хамаарах 2024 оны шударга байдлын үнэлгээний үзүүлэлтүүдээр

1.1.Шударга байдлын үнэлгээ /81 байгууллагаас/

- Ерөнхий үнэлгээ 2023 онд 78.0 оноо авч 39 дүгээр байрт эрэмбэлэгдсэн бол 2024 онд 80.5 болж 2.5 оноогоор өсөж, 9 дүгээр байрт эрэмбэлэгдэж байна. Энэ нь агентлагууд дундаас дунджаас дээгүүр үнэлгээтэйд тооцогджээ.
- Бодлогод оролцогчдын үнэлгээний хувьд 2023 онд 68.0 оноо авч 26 дугаар байрт эрэмбэлэгдсэн бол 2024 онд 75.4 болж 7.4 оноогоор нэмэгдэж, 8 дугаар байрт эрэмбэлэгдсэн Энэ нь бодлого боловсруулах болон хэрэгжилтэд оролцогчдын зүгээс илүү сайн үнэлгээ авсныг харуулж байна.
- Гадаад шударга байдлын үнэлгээ 2023 онд 70.7 авч, 2024 онд 79.6 болж 8.9 оноогоор өссөн буюу 25 дугаар байрнаас эхний 5 дугаар байрт эрэмбэлэгдсэн байна. Энэ нь байгууллагын ил тод байдал, хариуцлагын түвшин нэмэгдсэн гэж үзэх боломжтой.

1.2.Авлигын эрсдэлийн индекс

- Авлигын эрсдэлийн индекс 68.6 оноо авч 7 дугаар байрт эрэмбэлэгдсэн нь бусад 31 агентлагуудтай харьцуулахад дундаж түвшинд байна. Ил тод байдал +8.9, хариуцлагатай байдал +9.1, авлигын эрсдэлийн индекс өөрөө +9.0 гэсэн өсөлт үзүүлжээ.

1.3.Дэд үзүүлэлтүүдийн өөрчлөлтөөр буурсан үзүүлэлтүүд

- Бодлогод оролцогчдын дэд үнэлгээний Удирдлагын авлигатай тэмцэх хүсэл үзүүлэлт -4.3 оноогоор,
- Гадаад шударга байдлын дэд үнэлгээний Албан бус хэм хэмжээ -2.0, Төсвийн зарцуулалт -0,9 оноо, Үүрэг даалгаврын шударга байдал -0,4 оноогоор тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Дээрх мэдээлэлтэй холбоотойгоор Усны газраас 2025 онд дараах төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.

ХОЁР: БАЙГУУЛЛАГЫН ШУДАРГА БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭГ САЙЖРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн	Хугацаа /Сараар/	Хариуцах нэгж
Зорилт 1. Иргэд, аж ахуйн нэгжийн итгэлийг нэмэгдүүлэх, авлигын эрсдэлийг бууруулах					
1	Төсөв, худалдан авалтын мэдээллийг сар тутам цахим хуудсанд байршуулж, олон нийтэд танилцуулах	2025 оны эцэс гэхэд цахим хуудсанд байршуулсан төсөв, худалдан авалтын мэдээллийн хувь	100	5-12	Удирдлага санхүүгийн хэлтэс
2	Байгууллагаас гаргадаг шийдвэр бүхий дүгнэлтийн явцын ил тод байдлыг олон нийтэд ойлгомжтой байдлаар цахим системд байршуулах	Олон нийтэд зориулсан ил тод тайлангийн тоо	2	6, 12	УНХ, УАХ, УХШХ
Зорилт2. Албан хаагчдын ёс зүйн мэдлэг, хандлагыг нэмэгдүүлэх					
3	Авлигын эсрэг сургалт зохион байгуулах	Сургалтын хамрагдалтын хувь	90	5-12	Удирдлага санхүүгийн хэлтэс
4	Албан хаагчдад зориулсан ёс зүйн гарын авлага гаргаж, түгээх	Хэвлүүлсэн, бэлтгэсэн гарын авлага, материалын тоо	30	6	Удирдлага санхүүгийн хэлтэс
Зорилт 3. Үүрэг даалгаврын гүйцэтгэлийг нэмэгдүүлэх					

5	Дотоод хяналтыг сайжруулах хүрээнд Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн баталж, нийт албан хаагчдад танилцуулах	Шинэ журам батлагдсан байна.	1	6-12	Удирдлага санхүүгийн хэлтэс
6	Иргэдийн өргөдөл, санал, гомдлыг цахимаар хүлээн авч шийдвэрлэх байдалд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах	Хяналт шалгалтын тайлан	3	6, 9, 12	Удирдлага санхүүгийн хэлтэс
7	Үүрэг, даалгавар, шийдвэрийн хэрэгжилтийн явцын талаарх мэдээллийг нийт албан хаагчдад танилцуулах	Байгууллагын нийт албан хаагчдын нэгдсэн мэдээллийн системд байршуулсан мэдээллийн тоо	7	5-12	Удирдлага санхүүгийн хэлтэс

Товчилсон үг: -УНХ

-УАХ

-УХШХ

Усны нөөцийн хэлтэс

Ус ашиглалтын хэлтэс

Усны хяналт шинжилгээний хэлтэс

ХЯНАСАН:

УДИРДЛАГА САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА



Д.САЙХАНЖАРГАЛ

БОЛОВСРУУЛСАН:

ХУУЛЬ ТОГТООМЖ, ХАМТЫН АЖИЛЛАГАА

ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



Д.ЖАРГАЛ